



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	2
1 ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
2 ЖДҮ ЭРХЛЭГЧ НАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ	5
3 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БИЗНЕСИЙН ОРЧИН	6
3.1 Нийгэм, улс төрийн байдал	9
3.2 Макро эдийн засгийн нөлөө	12
3.3 Хууль, эрх зүйн зохицуулалт	15
3.4 Санхүүжилтийн орчин	18
3.5 Зах зээлийн орчин	21
3.6 Дотоод үйл ажиллагааны байдал	24
3.7 Дэд бүтцийн хөгжил	26
4 ЗАРДЛЫН БАЙДАЛ	27
5 ДҮГНЭЛТ	30
6 ХАВСРАЛТ	32



ӨМНӨХ ҮГ

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилтуудын нэг билээ. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг.

Монгол улсын Засгийн газраас ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, үүний хүрээнд 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлан гаргаж, 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар, 2009 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулсан. Төрөөс ЖДҮ-ийг хөгжүүлэх, бизнесийн орчинг сайжруулахад анхаарч 2009 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил”, 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”, 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ээр тус тус зарласан бөгөөд 2014 онд Засгийн газраас “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр (2014-2016)”-ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2016 оныг “Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих жил”-ээр зарлан жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой бодлого, үйл ажиллагааг гарган хэрэгжүүлж байна.

Монголбанкнаас Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлыг



тодорхойлох зорилгоор түүвэр судалгааг жил бүр, Улаанбаатар хот болон 21 аймаг дахь бизнес эрхлэгч нарын дунд явуулдаг.

Энэхүү түүвэр судалгааг Монголбанкнаас тав дахь жилдээ явуулж буй бөгөөд энэ жилийн хувьд Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй нийт 2000 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгч нарыг хамрууллаа. Судалгааг явуулахдаа “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг ангилж, түүвэрчлэн хамруулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн салбар, газар зүйн байршил, ажилчдын тоо зэргийг харгалзан үзэж санамсаргүй түүврийн аргаар судалгааны нэгжийг сонгон авсан болно.

Энэ удаагийн судалгаагаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийн өнөөгийн байдал, хөгжил, дэмжлэг, үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс, санхүүжилт болон зардлын байдлыг тодорхойлохыг зорилоо.

Монголбанкнаас 2016 оны 9 дүгээр сард ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан түүвэр судалгааны үр дүнг товчлон Та бүхэнд танилцуулж байна. Судалгааны дэлгэрэнгүй тайланг Монголбанкны судалгааны товхимлоос www.mongolbank.mn хаягаар орж харна уу.




1. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан энэхүү судалгаанд ААН-ийн дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотоос 1028, аймгуудын хувьд үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн тоог харгалзан тус бүр 30-50 орчим түүврийг сонгож, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 2095 ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгааны мэдээллийг түүвэрлэлтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс санал асуулга бөглүүлэх, ярилцлага авах хэлбэрээр бүрдүүлсэн. Судалгааны түүврийн ерөнхий мэдээлэл дараах байдалтай байна:


Үйл ажиллагааны төрөл




Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа



Ажилчдын тоо



Борлуулалтын орлого /жил/





Энэ удаагийн түүвэр судалгаанд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн (81%) чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай (78%), 3-с дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн (72%), жилийн 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой (77%) жижиг, дунд аж ахуйн нэгжүүд түлхүү оролцлоо.

2. ЖДҮ ЭРХЛЭГЧ НАРТ ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ

Засгийн газар, олон улсын байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын зүгээс ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилт олгох, сургалт, зөвлөгөөн явуулах, эрх зүйн орчинг сайжруулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, татварыг хөнгөвчлөх (татвар, НӨАТ-аас хөнгөлөх, чөлөөлөх) зэрэг дэмжлэгийг үзүүлдэг.

Төр, засгийн зүгээс ЖДҮ эрхлэгч нарт үзүүлж буй бодлого, үйл ажиллагааны дэмжлэг төдийлөн хангалттай бус, хэрэгжилт муу, хүртээмж багатай байдаг гэж бизнес эрхлэгчид шүүмжлэлтэй хандсан бөгөөд санхүүжилтийн тал дээр арилжааны банкуудаас өөр эх үүсвэрээс санхүүжилт авах боломж хомс байдаг байна. Олон улсын байгууллага болон Засгийн газраас (ЖДҮ-ийг дэмжих сангийн зээл, зээлийн батлан даалтын сан гэх мэт) үзүүлж буй санхүүжилтийн дэмжлэгийг банкуудаар дамжуулан олгодог тул ЖДҮ эрхлэгчид арилжааны банкыг бусадтай харьцуулахад илүү дэмжлэг үзүүлдэг гэж үзсэн байх боломжтой.



ЖДУ-ИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

Зураг 2-1. ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд

Хариултын хувь, давхардсан тоогоор



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 2-2. ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд

Хариултын хувь, давхардсан тоогоор



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Төр, засгийн зүгээс үзүүлж буй санхүүжилтийн болон бусад бодлого, үйл ажиллагааны дэмжлэгийг илүү хүртээмжтэй болгох, хэрэгжилтийг сайжруулах, төрийн үйлчилгээний олон шат дамжлагыг багасгаж чирэгдэл, хүнд суртлыг бууруулах, түүний зэрэгцээ санхүүжилтийн болон татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

3. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БИЗНЕСИЙН ОРЧИН


Жижиг, дунд үйлдвэрлэлийн судалгаанд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохдоо бизнесийн орчныг нийгэм, улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, хууль эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, зах зээлийн орчин, дэд бүтцийн хөгжил болон дотоод үйл

ажиллагааны байдал гэсэн бүлгүүдэд хуваан авч үзсэн.

Судалгааны үр дүнгээр манай улсын ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс нийгэм, улс төрийн байдал болон макро эдийн засгийн нөлөө хамгийн ихээр хүндрэл учруулж байна. Түүнчлэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулахад хууль, эрх зүйн орчны зохицуулалтууд хүндрэл учруулж байгаагаас гадна санхүүжилтийн орчин бизнес эрхлэхэд нэлээд хүндрэлтэй асуудал болж байгааг онцолсон. Макро эдийн засгийн хүндрэлтэй байдалтай уялдан зах зээлийн орчин муудаж улмаар бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа бол аж ахуйн нэгжүүдийн дотоод үйл ажиллагааны байдал болон дэд бүтцийн хөгжил бусад үзүүлэлтүүдээс харьцангуй боломжийн байна гэсэн үр дүн гарлаа.

Зураг 3-1. ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин¹

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа

¹ *Тайлбар: ЖДҮ эрхлэгчдийн чанарын хариултуудыг тоон утгад шилжүүлж, [-2; +2] хооронд утга авахаар индексжүүлж тооцсон.*



Хүснэгт 3-1. ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй гол хүндрэл, бэрхшээл

Өрсөлдөх чадварын тайлан ² /Монгол улс 2016/		ЖДҮ-ийн судалгаа /2016/	
1	Улс төрийн тогтворгүй байдал	Ажилгүйдэл, ядуурал	
2	Санхүүжилт	Валютын ханш	
3	Гадаад валютын зохицуулалт	Хээл хахууль	
4	Бодлогын тогтворгүй байдал	Улс төрийн байдал	
5	Төрийн үйлчилгээ, хүнд суртал	Инфляци /үнийн өсөлт/	
6	Татварын хувь, хэмжээ	Хэрэглэгчийн худалдан авах чадвар	
7	Мэргэшсэн ажиллах хүчний дутагдалтай байдал	Зээлийн хүү, шимтгэл хураамж	
8	Авлига, хээл хахууль	Эдийн засгийн өсөлт	
9	Татварын зохицуулалт	Хуулийн хэрэгжилт	
10	Ажиллах хүчний ёс суртахууны доголдол	Төрийн үйлчилгээ	
11	Инфляци	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	
12	Инновацийн чадамж	Татварын тогтолцоо	
13		...	

Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум: GCI 2016/2017

Дэлхийн эдийн засгийн форумгаас жил бүр эрхлэн гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадвар-2016” тайланд Монгол улс 138 орноос 102-т жагссан. Монгол улсын хувьд макро эдийн засгийн орчин муудсан, зах зээлийн багтаамж бага, дэд бүтэц сул, инноваци, санхүүгийн зах зээл, институцийн хөгжил доогуур байгаа нь өрсөлдөх чадвараар хойгуур жагсахад нөлөөлжээ.²

ЖДҮ эрхлэгчдийн судалгаагаар манай улсад бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг үзүүлэлтүүдээр авч үзвэл ажилгүйдэл, ядуурал, улс төрийн байдал, валютын ханш, төрийн үйлчилгээ, хүнд суртал, хуулийн хэрэгжилт болон зээлийн хүү, шимтгэл хураамж зэрэг нь гол хүндрэл учруулж байна. Энэ нь Өрсөлдөх чадварын тайлангийн үр дүнтэй нийцтэй үр дүн юм.

² Дэлхийн эдийн засгийн форум: Өрсөлдөх чадварын индекс 2016/2017




3.1 Нийгэм, улс төрийн байдал

ЖДҮ эрхлэгчдэд нийгэм, улс төрийн зүгээс үзүүлж буй нөлөө 2014 онд бага зэрэг сайжирсан ч сүүлийн хоёр жилийн судалгаагаар уг үзүүлэлт төдийлөн сайжраагүй бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд нь хамгийн муугаар нөлөөлж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлд нийгмийн зүгээс учруулж буй хамгийн гол бэрхшээлүүд нь ажилгүйдэл, ядуурал болон улс төрийн тогтворгүй байдал, хээл хахууль болж байна.

Зураг 3-2. Нийгэм, улс төрийн байдал

/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)



**Зураг 3-3. Нийгэм, улс төрийн байдал, үзүүлэлтээр
/Чиглэлийн индекс/**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин өсөх хандлагатай болсон нь өрхийн орлогыг бууруулж, ядуурлыг нэмэгдүүлэх, улмаар хэрэглэгчдийн худалдан авалтыг бууруулж, ААН-ийн орлогод сөргөөр нөлөөлж байна.


Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) гаргадаг өрхийн орлого, зарлагын тайланг авч үзвэл өрхийн сарын дундаж орлогын жилийн өсөлт 2015 оны III улирлаас эхлэн сөрөг түвшинд хүрч 2016 оны II улирлын байдлаар -9%-тай байгаа нь өрхийн орлого буурсан, улмаар хэрэглэгчдийн худалдан авах чадвар суларч байгааг харуулж байна.

Зураг 3-4. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: УСХ

Зураг 3-5. Өрхийн сарын дундаж орлого



Эх сурвалж: УСХ




3.2 Макро эдийн засгийн нөлөө

Макро эдийн засгийн зүгээс жижиг, дунд үйлдвэрлэлд үзүүлж буй нөлөө 2011 оноос хойш тасралтгүй муудсан бөгөөд энэ удаагийн судалгаагаар өмнөх жилүүдээс хамгийн муу дүнтэй гарлаа. Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн зүгээс төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт нь хамгийн их бэрхшээл болж байна.

Зураг 3-6. Макро эдийн засгийн нөлөө

/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 3-7. Макро эдийн засгийн нөлөө, үзүүлэлтээр
/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/




Эх сурвалж: Монголбанк, ЖДУ-ийн түүвэр судалгаа (2016)

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт нь импортын барааны үнийг өсгөх улмаар ААН-үүдийн үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Иргэдийн худалдан авах чадвар буурснаар ААН-үүдийн бараа, бүтээгдэхүүний үнэ (2016.III улирлын байдлаар инфляци -0.1%) тасралтгүй буурч байгаа нь бизнес эрхлэгчдийн борлуулалт, орлогод сөргөөр нөлөөлж байна.




Зураг 3-8. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3-9. Инфляци



Эх сурвалж: УСХ




3.3 Хууль, эрх зүйн зохицуулалт

Хууль эрх зүй, төрийн зохицуулалт нь ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч чухал хүчин зүйлсийн нэг бөгөөд өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг муудсан үзүүлэлттэй байна. Үүнд хуулийн хэрэгжилт сул, гадаад худалдаа хийх нөхцөл, боломж бага, төрийн байгууллагын үйлчилгээ муу зэрэг үзүүлэлтүүд голлон нөлөөлжээ.

Зураг 3-10. Хууль, эрх зүйн орчин

/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)



Зураг 3-11. Хууль, эрх зүйн орчин, үзүүлэлтээр /Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Дэлхийн банкнаас тооцдог засаглалын үзүүлэлтүүдийг авч үзвэл манай улсын хувьд авлига, хээл хахууль болон хуулийн хэрэгжилт сул байгаа нь засаглалын индекс хамгийн их сөргөөр нөлөөлдөг байна. Энэ нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хуулийн хэрэгжилтийг төдийлөн хангалттай дагаж мөрддөггүй, төрийн байгууллагын үйлчилгээ, хүнд суртал, чирэгдэл ихтэй байгаагаар тайлбарлагдаж болох юм.


Гадаад худалдааны хувьд экспорт, импортын хэмжээ сүүлийн хоёр жилд огцом буурсан бөгөөд гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 10 хувиар агшсан байна. Гадаад болон дотоод эдийн засгийн орчны таагүй нөхцөл байдал, дотоод дахь тээвэр, логистик, худалдааны татвар зэрэг хүчин зүйлсээс хамаарч бизнес эрхлэгчдэд гадаад худалдаа хийх нөхцөл, боломж муу байгааг харуулж байна.

Хүснэгт 3-2. Монгол улсын засаглалын индекс

	2011	2012	2013	2014	2015
Дуу хоолой ба хариуцлагатай байдал	0.00	0.03	0.07	0.23	0.24
Улс төрийн тогтвортой байдал	0.60	0.47	0.49	0.76	0.65
ЗГ-ын үр ашигт байдал ³	-0.58	-0.63	-0.54	-0.41	-0.40
Зохицуулалтын байдал ⁴	-0.20	-0.20	-0.31	-0.25	-0.33
Хуулийн хэрэгжилт	-0.30	-0.39	-0.38	-0.35	-0.39
Авлигын хяналт	-0.68	-0.53	-0.48	-0.47	-0.47
Тэмдэглэл: Засаглалын индекс нь -2.5 аас +2.5 хооронд орших бөгөөд +2.5 тай ойролцоо байвал засаглалын чанар сайн, харин -2.5-тай ойр байвал засаглалын чанар доогуур түвшинд байгааг харуулна.					

Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 3-12. Гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк

³ Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар зэргийг энэ бүлэгт хамруулан ойлгоно.

⁴ Засгийн газрын эдийн засгийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх чадварыг илэрхийлнэ.




3.4 Санхүүжилтийн орчин

Хөгжиж буй улсуудын нэгэн адил манай улсад ЖДҮ эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь санхүүжилтийн асуудал юм. Ялангуяа, зээлийн нөхцөл хатуу (хүү өндөр, хэмжээ бага, хугацаа богино), барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй, хөнгөлөлттэй зээлийн олдоц хомс, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хөгжил сул зэрэг нь бизнес эрхлэгчдэд санхүүгийн асуудлаа шийдвэрлэхэд хүндрэл болж байна.

Зураг 3-13. Санхүүжилтийн орчин

/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 3-14. Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр

/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)


Банкны зээлийн хүү макро эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдан төдийлөн буурахгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн орчны зүгээс хамгийн их хүндрэл учруулж байна. Тухайлбал, ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-д олгож буй банкны зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 18.2%-тай байна. Түүнчлэн банкнаас зээл авахад тодорхой хувийг зээлийн болон үйлчилгээний шимтгэл хураамжийн төлбөрт авдаг нь ААН-үүдийн хувьд санхүүгийн хүндрэл учруулж байна.

ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хугацаа 25.4 сар буюу 2 жил гаруй байгаа нь бизнесийн үйл ажиллагаатай бүрэн уялддаггүй, богино хугацаанд зээлээ эргэн төлөхөд ихээхэн хүндрэлтэй байдаг гэж судалгаанд оролцогчид онцолжээ.

Зээлийн барьцаа хөрөнгөгүй, хөрөнгийн үнэлгээ бага, зээлийг шаардлагатай хэмжээнд бүрэн олгодоггүй болон зээлийн батлан даалтад хамрагдах байдал зэрэг нь хүндрэлтэй асуудал хэвээр байна.



Зураг 3-15. Зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 3-3. Зээлийн дундаж хугацаа

Зээлийн төрөл	Дундаж хугацаа /сар/
Иргэдийн зээл	60.6
Цалингийн зээл	30.9
Хэрэглээний зээл	14.9
Тэтгэврийн зээл	4.1
Ипотекийн зээл	22.7
Бусад зээл	12.9
ЖДҮ-ийн зээл	25.4
Иргэд	28.2
Аж ахуй нэгж	23.9

Эх сурвалж: Монголбанк


3.5 Зах зээлийн орчин

Судалгааны үр дүнгээр бизнес эрхлэгчдийн хувьд зах зээлийн орчны нөлөө сүүлийн хоёр жилд нэлээд муудсан үзүүлэлттэй байна. Үүнд хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурсан, зах зээлийн багтаамж хумигдсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 3-16. Зах зээлийн орчин

/Чиглэлийн индекс/

/-2=маши муу, -1=муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маши сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)



Зураг 3-17. Зах зээлийн орчин, үзүүлэлтээр
/Чиглэлийн индекс/


/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Эдийн засгийн хүндрэлтэй байдал үргэлжилж, иргэдийн орлого төдийлөн өсөхгүй байгаа нь иргэдийн худалдан авах чадвар муудахад нөлөөлж байна. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудан, хэрэглээ хумигдаж (жилийн бодит өсөлт -15%) нийт эрэлт буурч байгаа нь ААН-үүдийн хувьд бараа, бүтээгдэхүүнээ борлуулах, шинээр бараа, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлж улмаар зах зээлийн багтаамж хумигдахад хүргэж байна.

Зураг 3-18. Бодит цалин



Эх сурвалж: ҮСХ

Зураг 3-19. Нийт хэрэглээ



Эх сурвалж: ҮСХ




3.6 Дотоод үйл ажиллагааны байдал

Дотоод үйл ажиллагааны нөхцөлийн хувьд бараа бүтээгдэхүүний борлуулалт, ажиллах хүчний нийлүүлэлт болон ажилчдын ур чадвар бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага зэрэг хүндрэлтэй гэсэн үр дүн гарлаа.

Зураг 3-20. Дотоод үйл ажиллагаа


/Чиглэлийн индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 3-21. Бөөний/жижиглэнгийн худалдаа



Эх сурвалж: УСХ

Бөөний болон жижиглэнгийн худалдааны борлуулалтыг авч үзвэл сүүлийн 3 жилийн хугацаанд өсөлт нь саарч сөрөг түвшинд дөхсөн нь ААН-үүдийн борлуулалт муудаж байгааг харуулж байна.

Түүнчлэн мэргэжлийн, өндөр ур чадвартай боловсон хүчний нийлүүлэлт харьцангуй муу байгаа нь бизнес эрхлэгчдэд багагүй хүндрэл учруулдаг байна.




3.7 Дэд бүтцийн хөгжил

Бизнес эрхлэхэд чухал хүчин зүйлсийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. ЖДҮ эрхлэгчдийн хувьд дэд бүтцийн хөгжил ерөнхийдөө муу гэж үзсэн ч бусад орчны индексүүдтэй харьцуулахад хамгийн сайн үзүүлэлттэй гарлаа.

Зураг 3-22. Дэд бүтцийн хөгжил /Чиглэлийн индекс/


/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 3-23. Дэд бүтцийн хөгжил, үзүүлэлтээр /индекс/

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)



ЖДҮ эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад нь мэдээлэл холбоо, цахилгаан түгээлт харьцангуй боломжийн байгаа бол зам тээвэр, дулаан, усан хангамжийг үргэлжлүүлэн сайжруулах, шинээр зам барих болон засварын ажлыг түргэн, шуурхай хийж гүйцэтгэж байх шаардлагатай байна.

4. ЗАРДЛЫН БАЙДАЛ

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь зардлын үр ашигт байдал чухал нөлөөтэй. Бизнес эрхлэгчид үйл ажиллагааны үндсэн бус зардал болох зээлийн хүү болон шимтгэл хураамж (санхүүгийн байгууллагын)-ийн төлбөр нь зардлын хувьд хамгийн их хүндрэлтэй байна. Тухайлбал, зээлийн хүү болон шимтгэл хураамжийн төлбөр нь нийт зардлын 15 орчим хувь буюу нэлээд өндөр хувийг эзэлж байна.

ЖДҮ эрхлэгчдийн нийт зардлын хамгийн өндөр буюу 42.9%-ийг үйл ажиллагааны үндсэн зардал болох түүхий эд материал, ажилчдын цалингийн зардал эзэлж байна. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт нь шууд болон шууд бусаар түүхий эд материал, тоног төхөөрөмжийн зардлыг нэмэгдүүлж байгаа нь ААН-үүдэд багагүй хүндрэл болж байна.

Харин 38.4%-ийг үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд буюу цахилгаан, дулаан, харилцаа холбоо, тээвэр болон түрээсийн зардлууд эзэлж байна.



Зураг 3-24. Зардлын байдал, үзүүлэлтээр /Чиглэлийн индекс/


/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, +1=сайн, +2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)

Зураг 3-25. Зардлын хуваарилалт / % /

Эзлэх хувиар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ-ийн түүвэр судалгаа (2016)



5. ДҮГНЭЛТ

Гадаад орчны таагүй нөхцөл байдал, түүнээс үүдэлтэй дотоод эдийн засгийн хүндрэл, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хөгжил сул байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад бэрхшээл учруулж байна. Эдийн засгийн хүндрэлтэй байдал тэр дундаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт үргэлжилж түүхий эд, тоног төхөөрөмжийн зардлыг өсгөх, нөгөө талаас ажилгүйдэл нэмэгдэж хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудсанаар бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Бизнесийн орлого муудсанаар ААН-үүд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд хүндрэл учирч байна. Түүнчлэн үйлдвэрлэлээ өргөтгөх, хэвийн үргэлжлүүлэхэд санхүүжилтийн бэрхшээл хамгийн ихээр тулгарч байна. ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй биш, олдоц бага бөгөөд арилжааны банкуудын зээлийн нөхцөл хатуу, шалгуур өндөр байгаа нь санхүүжилтийн орчны гол бэрхшээл болж байна. Түүнчлэн банкны зээлийн хүү өндөр, хэмжээ бага, олгосон хугацаа нь бизнесийн үйл ажиллагаатай уялдахгүй байгаа нь найдваргүй зээлдэгч болох эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар дахин зээл авахад хүндрэлтэй байгааг судалгаанд оролцогчид онцолж байна.

Иймд төр, засгийн зүгээс бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, тэр дундаа санхүүжилт болон татварын оновчтой бодлого явуулах шаардлага тулгарч байна. Тухайлбал:

- Төр, хувийн хэвшлийн харилцааг хууль, журмын хүрээнд явуулж, хүнд суртал, чирэгдлийг багасгах,
- Төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлийн



хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олгох үйл явцыг сайжруулах, нээлттэй ил тод болгох, ажлын байрыг ихээр бий болгодог импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх төслүүдийг дэмжиж хөгжүүлэх,

- Шинээр бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны эхний үе шатанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж үйл ажиллагаа нь тогтворжсон үед татвар ногдуулах боломжийг судлах,
- Дотоодод үйлдвэрлэх бүрэн боломжтой хэдий ч импортоор авч хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүнүүдийн хувьд татварын болон бусад зохицуулалтын замаар дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах, цаашид дэмжих арга хэмжээнүүдийг судлан авч хэрэгжүүлэх.



6. ХАВСРАЛТ

МОНГОЛ УЛС ДАХЬ ЖДҮ-ИЙН ХӨГЖЛИЙН ТОВЧ ХУРААНГУЙ

- 1994 онд Монгол улсын Засгийн газар Дэлхийн Банктай хамтран “Ядуурлыг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.
- 1996 онд Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гол байгууллагуудын нэг Хадгаламж зээлийн хоршоо байгуулагдсан.
- 1997 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс (НҮБХХ) Монгол улсын төрийн бус 6 байгууллагаар дамжуулан “Микростарт” төслийг хэрэгжүүлж эхэлсэн.
- 1998 оноос хойш бичил санхүү нь ядуурлыг бууруулах, хөрөнгөтэй болох, орлогоо нэмэгдүүлэх хүчтэй арга хэрэгсэл болон хөгжиж эхэлсэн.
- 1999 онд анхны Банк бус санхүүгийн байгууллага байгуулагдсан.
- 2002 онд анхны “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа”-ны тухай хууль батлагдсан.
- 2004 онд Монгол улсад “Бичил зээл ба бизнес” үндэсний чуулган зохион байгуулагдсан.
- 2005 оныг Монгол улсын Засгийн газраас “Бичил санхүүгийн жил” болгон зарласан.
- 2005 онд “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг Засгийн газраас баталсан.
- 2005-2006 онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор тус бүр 1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргасан.
- 2006 онд бичил санхүүгийн үйл ажиллагааг хянан зохицуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороог байгуулсан.



- 2007 онд “Жижиг, дунд үйлдвэр”-ийн тухай хууль батлагдсан.
- 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар шинээр байгуулагдсан.
- 2009 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас 2012 оныг дуустал чөлөөлөх тухай хуулийг УИХ баталсан.
- 2009 онд “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг Засгийн газар шинэчлэн баталсан.
- 2009 онд “ЖДҮ-ийг хөгжүүлэх сан”-г байгуулсан.
- 2009 онд “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийг Засгийн газраас баталсан.
- 2009 онд “Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газраас баталсан.
- Санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан бий болгох нөхцөл боломжийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулахаар Монголын Хөрөнгийн Биржтэй хамтарч ажиллахаар болсон.
- Засгийн газраас ЖДҮ-ийг дэмжих инкубатор төвүүдийг нийслэл хот болон аймгуудад байгуулж эхэлсэн.
- 2009-2010 онуудад ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар 60.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хуваарилж зээлдүүлсэн.
- 2010 онд ЖДҮ-үүдэд зориулж олгох 25 сая ам.долларын зээлд АНУ-ын “Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн зээлийн хөтөлбөр”-өөс баталгаа гаргасан.
- 2010 оны байдлаар нийт ААН-үүдийн 90 орчим хувийг ЖДҮ эзэлж, 300 мянга орчим хүн ажиллаж байна.



- 2010 онд Европын комиссоос манай улсын жижиг, дунд үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр 4 сая еврогийн буцалтгүй тусламжийг олгохоор болсон.
- 2010 онд Монгол улсын ЖДҮ-ийг хөгжүүлэх үүднээс Япон улсын Засгийн газраас 75 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2 үе шаттайгаар хийхээр боллоо.
- 2011 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар арилжааны банкуудаас 48 мянга гаруй зээлдэгчдийг санхүүжүүлж, зээлийн өрийн үлдэгдлийн дүн нь 690 тэрбум (нийт зээлийн өрийн үлдэгдлийн 19%) төгрөг болж 2010 оны эцсээс 65 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.
- 2012 оныг “Сум хөгжүүлэх сан”-г байгуулсан.
- 2012 оныг “Өрхийн бизнесийг дэмжих жил” болгон зарласан.
- 2012 онд УИХ-д “Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо” байгуулагдан ажилласан.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 оныг дуустал чөлөөлсөн.
- Газар, тариалан, ойн аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмжийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас, тэдгээрийг дотоодод борлуулсан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 оныг дуустал чөлөөлсөн.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлсөн.
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож байгаа



зээлийн дээд хэмжээ 50 сая байсныг 500 сая төгрөг, зээлийн хугацааг 3 жил байсныг 5 жил, хүүг жилийн 12 хувьтай байсныг 7 хувь болгох зэрэг санхүүгийн хөнгөлөлтүүдийг бий болгосон.

- 2012 онд “Зээлийн Батлан Даалтын Сан”-г үүсгэн байгуулсан.
- 2014 онд “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)” батлагдсан.
- 2015 онд МҮХАҮТ-аас ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, гадаад дотоодын зах зээлд сурталчлах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь туслах ажлын хүрээнд хөрөнгө оруулалт хайж буй аж ахуйн нэгжүүдийн төслийн мэдээллийн бааз үүсгэсэн.

